



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 02

Арвайхээр


Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны
нөөцийн жагсаалтад бүртгэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын есдүгээр зүйлийн 32, 33 дахь заалтууд, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 14 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлт гаргах заавар"-ын тав, зургаадугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн Балжиннямын Долгорсүрэнг Хайрхандулаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын, Агвааны Батсайханыг тус сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад тус тус бүртгэсүгэй.

2. Энэ тогтоолын нэгдүгээр заалтаар төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Балжиннямын Долгорсүрэнг Хайрхандулаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд, Агвааны Батсайханыг тус сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд тус тус томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

013100003